

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
2019 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2020/02/-НА

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор 2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Бүнчинсүрэн
Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn
Аудитор: Б.Цэрэнчимэд
Утас: 88117644 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Тайланг хянасан:**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

А.Цээням

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор

М.Алтантуяа

Аудитор

Б.Цэрэнчимэд

Н.Бүнчинсүрэн

2020 оны 11 дүгээр сарын 04

Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-64000
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	2
Аудитын зорилт	2
Аудитын хамарсан хүрээ	2
Аудитын арга зүй	2
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	2
Товчилсон үгийн тайлбар	3
АУДИТЫН ДҮН	4
Бүлэг 1. ОНХНС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг төлөвлөснөөс 193.5 сая төгрөг дутуу олгосон, аймаг сумдын ОНХС-д орох хандив, тусламжийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 291.2 сая төгрөгөөр тасарч, санхүүжилтийг хуваарийн дагуу хийгээгүйгээс төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.	4
1.1 Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээр ОНХНС-гаас Баянхонгор аймагт 6,485.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 193.5 сая төгрөг дутуу олгожээ.	4
1.2 Сумдад олгох орлогын шилжүүлгийг төсвийн хуваарийн дагуу олгоогүй нийт санхүүжилтийн 57 хувийг 9-12 сард олгосон нь аймагт ОНХНС-гаас олгож буй орлогын шилжүүлэгээс хамаарч байна.	5
Бүлэг 2. Зарим сумын ИТХ багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцээгүй 14 төсөл арга хэмжээнд 144.9 сая, Төсвийн тухай хуулийн 60.3.1 –т заасан заалтыг зөрчин 73.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 1,628.1 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	8
2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Жаргалант, Заг, Бөмбөгөр, Өлзийт сумууд 144.9 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг иргэдийн санал аваагүй ажлыг ИТХ-р баталсан байна.	8
2.2 ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 60.3.1 –т заасан заалтыг зөрчин 73.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 заалтыг зөрчин 1,628.2 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	11
Бүлэг 3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээнд аймгийн ЗДТГ хууль, журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй, ОНХС-гийн 2019 оны үйл ажиллагааны тайланг ХОХБТХ Сангийн яаманд хүргүүлээгүй, ОНХС-гаас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ орон нутагт бодит дэмжлэг болж байгаа боловч зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй, арчлалт хамгаалалт байхгүйгээс хөрөнгө эзэнгүйдэж, сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.	16
3.1 Баянхонгор аймгийн ОНХС-гийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт хийгээгүй, мөн Галуут, Богд, Бууцагаан сумд ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.....	
3.2 Өмнөх оны аудитын зөвлөмжөөр өгсөн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулдаг, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй зэрэг зөрчлүүд тайлант онд давтагдсаар байна.	19
3.2.3 ОНХС-гийн хөрөнгөөр 2016-2019 онуудад хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээ орон нутагт бодит үр дүнгээ өгч байхад түүвэрлэн үзсэн ажлуудаас 753,5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хангалтгүй хийгдэж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.	22
УАГ-ААС ӨГСӨН ЧИГЛЭЛ	23
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ	27
АУДИТЫН ДҮГНЭЛТ	28
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	29

**АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**Аудит хийсэн
үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/53 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн нэгдсэн удирдамжаар Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх

Аудитын хамарсан
хүрээ

Аудитыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2019 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг Баянхонгор аймгийн ИТХ, ЗДТГ болон, сумдын ИТХ, ЗДТГ-ыг хамруулан шалгав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;

Засгийн газрын тогтоол:

- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;

Сангийн сайдын тушаал:



ААН
ЗДТГ
ЖДҮ
ИТХ
ИНХ
НА
ОНХНС
ОНХС
СТСХ
ТАГ
ТЕЗ
ТЭЗҮ
УИХ
УТХО
ҮАГ
ХО
ХОХБТХ

- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”

Товчилсон үгийн тайлбар

Аж ахуйн нэгж
Засаг даргын тамгын газар
Жижиг дунд үйлдвэрлэл
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
Иргэдийн нийтийн хурал
Нийцлийн аудит
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
Орон нутгийн хөгжлийн сан
Санхүү, төрийн сангийн хэлтэс
Төрийн аудитын газар
Төсвийн ерөнхийлөн захирагч
Техник, эдийн засгийн үндэслэл
Улсын их хурал
Улсын төсвийн хөрөнгө оруулалт
Үндэсний аудитын газар
Хөрөнгө оруулалт
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс



АУДИТЫН ДҮН

ОНХС-гийн санхүүжилтээр хийгдсэн төсөл арга хэмжээ орон нутагт бодиттой дэмжлэг болж байгаа боловч зарим хөрөнгийн ашиглалт муу, хамгаалалт, арчлалт байхгүйгээс хөрөнгө эзэнгүйдэж, сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Бүлэг1. ОНХС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг төлөвлөснөөс 193.5 сая төгрөг дутуу олгосон, аймаг сумдын ОНХС-д орох хандив, тусламжийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 291.2 сая төгрөгөөр тасарч, санхүүжилтийг хуваарийн дагуу хийгээгүйгээс төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

1.1 Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээр ОНХС-гаас Баянхонгор аймагт 6,485.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 193.5 сая төгрөг дутуу олгожээ.

1.1.1 Төсвийн тухай хуулийн 59.3¹ дахь заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу тооцон төлөвлөж, Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар Баянхонгор аймагт ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг 6,485.9 сая төгрөг, аймгийн ОНХС-д 3,026.1 сая, 20 сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн 2,821.2 сая, Төсвийн тухай хуулийн 58.2.12²-т заасан мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 517.5 сая, 58.2.15³-д заасны дагуу хот тохижилт үйлчилгээний зардалд 121.0 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

1.1.2 ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн дагуу 6,485.9 сая төгрөгийг доорх эх үүсвэрээс оруулахаар тооцсон байна.Үүнд:

Баянхонгор аймагт ОНХС-гийн 2019 оны төлөвлөгөө

Хүснэгт1

№	АЙМАГ	Жилийн төлөвлөгөө /сая төг/						
		Дотоодын НӨАТ 5%	Газрын тосны НАТ 30%	АМНАТ 5%	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 50%	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох		Нийт
						Урамшуулал	Дэмжлэг	
3	Баянхонгор	1,648.7	646.1	2,666.7	659.1	311.8	553.4	6,485.9

¹ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

² 58.2.12.мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

³ 58.2.15.аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, ийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;



1.1.3 ОНХНС-аас Баянхонгор аймагт 6,485.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 6,292.4 сая төгрөг шилжүүлж 193.5 сая төгрөгийг дутуу олгосон. ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгосон эсэхийг хүснэгтээр харуулбал 3-р улирлын байдлаар 625,8 сая төгрөг дутуу олгосон, 4-р улиралд 432,3 сая төгрөгийг нөхөж олгосон байна.

Үзүүлэлт	Жилийн төлөвлөгөө	I улирлын дүн	II улирлын дүн	III улирлын дүн	IV улирлын дүн
Батлагдсан төсөв	6,485.9	746.8	2,140.8	1,859.7	1,738.5
Олгосон санхүүжилт	6,292.4	670.2	2,087.2	1,364.1	2,170.8
Дутуу санхүүжилт	(193.5)	(76.6)	(53.6)	(495.6)	432.3
гүйцэтгэлийн хувь	97%	90%	97%	73%	125%

1.2 Сумдад олгох орлогын шилжүүлгийг төсвийн хуваарийн дагуу олгоогүй нийт санхүүжилтийн 57 хувийг 9-12 сард олгосон нь аймагт ОНХНС-гаас олгож буй орлогын шилжүүлэгээс хамаарч байна.

1.2.1 Аймгийн ИТХ-ын 2018 оны 14/03 тоот хуралдааны тогтоолоор аймгийн ОНХС-гийн хөрөнгөд 3,571.4 сая төгрөг төлөвлөснөөс ОНХС-гаас 3,026.1 сая, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эх үүсвэрээс 30 сая, ТЭЗҮ-ээс 132.3 сая, хандив тусламжийн орлогоос 350.0 сая, орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн эх үүсвэрээр, аймгийн ОНХС-гаас сумдад олгох орлогын шилжүүлгийг 2,821.3 сая төгрөгөөр, мал эмнэлгийн үйлчилгээнд 517.5 сая, хот тохижилтын үйлчилгээнд 121.0 сая төгрөгийг тус тус баталжээ.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 4-р сарын 19-ны өдрийн 16/02 тоот тогтоолоор 2018 оны 6 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 215.9 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэх, мөн өдрийн хуралдааны 16/03 тоот тогтоолоор “Цахилгаан халаагуураар иргэдийг хангах” 100.0 сая төгрөгийн ажлыг ОНХС-аас хасаж ангилагдаагүй зардлаар санхүүжүүлэхээр тус тус тодотгож аймгийн ОНХС-д 3,687.3 сая төгрөг олгохоор баталсан байна.

Сумдын ИТХ-аар аймгийн ОНХС-гаас 2,821.3 сая, хандив тусламжийн орлогоос Баян-Овоо сум 195.0 сая, Галуут сум 10.0 сая, Баянговь сум 36.2 сая нийт 241.1 сая, өмнөх оны үлдэгдлээс 925.1 сая, орон нутгийн төсвөөс Баацагаан сум 26.0 сая, Заг сум 4.4 сая, Баянбулаг сум 8.0 сая, өвс тэжээл, малжуулахын эргэн төлөлтийн орлогоос 97.1 сая төгрөгийг оруулахаар нийт 4,123.0 сая төгрөг баталсан бөгөөд аймгийн дүнгээр ОНХС-гийн эх үүсвэрийг 8,448.8 сая төгрөгийг аймаг сумын ИТХ-аар баталжээ.



Тодруулга: Жинст сум ИТХ-аар 2018 оноос шилжин ирсэн 3 төсөл арга хэмжээнд 17.3 сая төгрөг тодотголоор баталсан бөгөөд тус тодотголыг CTCX-ийн мэргэжилтэнд ирүүлээгүйгээс Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд орхигдуулсныг 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд зөрчлөөр тусган зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсний дагуу 2020.09.28-ны өдөр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн байна.

1.2.2. Аймгийн ОНХС 2019 онд Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан нэр төрлийн дагуу нийт 8,076.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээс бүрдүүлжээ. ОНХС-д тайлант онд 7,114.6 сая төгрөгийн орлого төвлөрч 372.0 сая төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдсэн нь ОНХС-гаас 193.5 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон, хандив тусламжийн орлогын төлөвлөгөө 291.2 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна./Хавсралт №1/

ОНХС-гийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн гүйцэтгэлийн төрлөөр харуулбал:

Хүснэгт 2

Диаграмм 1

ОНХС-гийн эх үүсвэр нэр төрлөөр	Мөнгөн дүн /сая төг/
ОНХНС	6,292.4
Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр	30.0
Орон нутгийн төсвөөс	174.9
ТЭЗҮ	112.7
Хандив тусламжаас	300.2
Өвс тэжээл борлуулах, малжуулах, бусад	204.5
ОНХС-гийн өмнөх оны үлдэгдэл	962.3
Нийт орлого	8,076.9



Аймаг, сумдын ОНХС-ийн харилцах данс нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 853.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-гийн 2019 оны орлого зарлагын судалгаа

Хүснэгт 3 /сая төгрөг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХС-гийн орлогын шилжүүлэг	Бусад орлого	Нийт орлогын дүн	Нийт зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Сумдын дүн	940.5	2,821.3	393.0	3,214.3	3,302.0	852.8
2	Аймгийн ОНХС	21.7	3,471.1	429.2	3,900.3	3,921.7	0.4
	Аймгийн нийт дүн	962.3	6,292.3	822.3	7,114.6	7,223.7	853.2



1.2.3 Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/03 тоот тогтоолоор Төсвийн тухай хуулийн 59.2⁴ дахь заалт болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу сумдад 2,821.3 сая төгрөгийг хуваарилж, аймгийн ОНХС-д 3,664.6 сая төгрөг нийт 6,485.9 олгохоор баталсан.

2019 онд аймаг, сумдын ОНХС-д олгохоор тооцсон орлогын шилжүүлгийг сум тус хүснэгт 4-ээр харуулбал:

2019 онд аймаг, сумдын ОНХС-д олгохоор
тооцсон орлогын шилжүүлэг

Хүснэгт 4 /сая төгрөг/

Сумдын нэр	Төсвийн тухай хуулийн 59.3-д заасан	Төсвийн тухай хуулийн 60.2.7-д заасан	Төсвийн тухай хуулийн 60.2.5-д заасан	Нийт батлагдс ан	Сумдын нэр	Төсвийн тухай хуулийн 59.3-д заасан	Төсвийн тухай хуулийн 60.2.7-д заасан	Төсвийн тухай хуулийн 60.2.5-д заасан	Төсвийн тухай хуулийн 58.2-д заасан	Нийт батлагдс ан
Баацагаан	66.1	5.3	47.5	118.9	Галуут	55.7	16.9	23.7		96.3
Баянбулаг	42.6	0.4	30.5	73.4	Гурванбулаг	51.7	-	37.1		88.8
Баянговь	63.5	15.0	27.1	105.6	Жаргалант	53.0	-	38.0		91.0
Баянлиг	100.2	54.6	72.1	227.0	Жинст	40.1	42.2	17.1		99.5
Баян-Овоо	29.7	20.9	21.3	72.0	Заг	38.6	-	27.7		66.2
Баян-Өндөр	104.8	75.7	75.8	256.3	Өлзийт	38.5	27.6	27.7		93.8
Баянхонгор	184.1	-	132.5	316.7	Хүрээмарал	42.9	16.6	31.1		90.7
Баянцагаан	77.7	10.8	56.0	144.5	Шинэжинст	97.3	319.5	69.9		486.6
Богд	49.3		35.5	84.8	Эрдэнэцогт	44.4	-	31.9		76.3
Бөмбөгөр	44.7	52.5	32.0	129.2	Сумдын дүн	1,296.9	659.1	865.2		2,821.3
Бууцагаан	71.9	1.1	30.6	103.6	Баянхонгор аймаг	3,026.1	-	-	638.5	3,664.6
НИЙТ ДҮН						4,323.0	659.1	865.2	638.5	6,485.9

Дээрх хүснэгтийн дагуу сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг төлөвлөсний дагуу олгожээ. ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу Ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг Төсвийн тухай хуулийн 60.5⁵-д, 60.6-⁶д заасны дагуу аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс тодруулга авахад ОНХС-гийн орлогоор сумдад төлөвлөж АМХБАТЗ-ийн төлбөрийн 50%-ийг Баянхонгор аймагт нийт дүнгээр 659.1 сая төгрөгийг сумдад олгохоор төлөвлөж, хуваарилсны дагуу Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийг нээж олгосон. Аймаг дээр дээрх орлогыг сумдаар гүйцэтгэлийг гаргаж хуулийн дагуу хуваарилсан эсэхийг үзэх боломжгүй байна.


⁴ 59.2. Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.

⁵ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно

⁶ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно"



Аймгийн ОНХС-д ОНХНС-аас 2019 онд олгосон нийт санхүүжилтийн 14%-ийг эхний 4 сард, 22%-ийг 5-р сард, 23%-ийг 6-8 сард, 41%-ийг 9-12 сард олголт хийгдсэн байна. Сумдад олгосон санхүүжилтийг ОНХС-гийн төсвийн хуваарийн дагуу олголт хийгдэж буйг шалгахад нийт санхүүжилтийн 28 % нь 5 сард, бусад санхүүжилт нь 9-12 сард 57% олгогдож байгаа харагдаж байна. Энэ нь ОНХНС-аас олгож буй санхүүжилттэй уялдаж байна.



Бүлэг 2. Зарим сумын ИТХ багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцээгүй 14 төсөл арга хэмжээнд 144.9 сая, Төсвийн тухай хуулийн 60.3.1 –т заасан заалтыг зөрчин 73.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 1,628.1 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Жаргалант, Заг, Бөмбөгөр, Өлзийт сумууд 144.9 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг иргэдийн санал аваагүй ажлыг ИТХ-р баталсан байна.

2.1.1 Баянхонгор аймгийн 20 сум өмнөх оноос шилжиж ирсэн 45 ажилд 476.0 сая, тайлант оны 235 ажилд 3,646.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, ОНХС-аас 2,821.3 сая, хандив 241.2 сая, өмнөх оны үлдэгдэл 925.1 сая, орон нутгийн төсвөөс 38.4 сая, өвс тэжээлийн үнэ, малжуулах болон бусад орлогоос 97.1 сая төгрөг нийт 4,123.0 сая төгрөгийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс саналыг авч эрэмбэлэн багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн сумын ИТХ-д өргөн мэдүүлсэн ба харин Бөмбөгөр, Заг, Жаргалант, Өлзийт нийт



144.9 сая төгрөгийн 7 ажилд иргэдээс санал аваагүй баталж Төсвийн тухай хуулийн 60.3.6⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Бөмбөгөр суманд 7 төсөл арга хэмжээнд 34.2 сая төгрөг
- Өлзийт сум: Сумын төвийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл 88.7 сая, нийтийн биеийн тамирын тоног төхөөрөмж худалдан авах 5.1 сая төгрөг
- Жаргалант сум: Хог ачих автомашин худалдан авах 35.0 сая төгрөг, сумын төвийн хаягжуулалд 9.2 сая төгрөг, хогны бункер 2.4 сая төгрөг.
- Заг сум: Баян-Улаан багт иргэний танхим байгуулах 3.6 сая, цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайг хайсжуулах 0.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцээгүй, иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар баталсан байна. Цаашид зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.


Иймд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ ИТХ-аар батлагдаагүй, төсөл арга хэмжээний эрхийг нээж санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох зөвлөмжийг СТСХ-ийн даргад хүргүүлэв.

2.1.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 45 төсөл, арга хэмжээнд 4,325.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн нь “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичиг, аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумдын хөгжлийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичиг, Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байна.

Аудитын

явцад аймаг сумын нийт 661 иргэдээс авсан санал асуулга авсан ба санал асуулгын нэгтгэлээс ОНХС-гийн

төлөвлөлтөд оролцох иргэдийн оролцоо нэмэгдсэн, ОНХС-гийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээлэл болон баг хороодын Засаг дарга нараас



⁷ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ зарцуулахыг хориглоно.



түлхүү авдаг гэсэн үр дүн гарсан ба сумдаар нь дотор нь дэлгэрэнгүй харахад Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Шаргалжуут тосгоны иргэд ОНХС-гийн талаарх мэдлэг байхгүй, сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын талаар мэдээлэл дутмаг байгаад цаашид анхаарч ажиллах нь зүйтэй.





2.2 ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 60.3.1 –т заасан заалтыг зөрчин 73.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.48 заалтыг зөрчин 1,628.2 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

2.2.1 Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,562.2 сая төгрөгийн 263 төсөл арга хэмжээнээс ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу 244 төсөл арга хэмжээний 5,308.4 сая төгрөгийн ажилд сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулжээ.

Үүнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1⁹-д заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар 27 төсөл, арга хэмжээнд 2,563.3 сая төгрөг, харьцуулалтын аргаар 50 төсөл арга хэмжээнд 1,390.9 сая төгрөг, 167 төсөл арга хэмжээнд 1,354.1 сая төгрөгийн шууд гэрээ байгуулжээ. Огт хэрэгжээгүй, санхүүжилт аваагүй 19 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа хийгдээгүй байна.

Харин Эрдэнэцогт сум 11.0 сая, Шинэжинст сум 73.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээг сонгон шалгаруулалт явуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Эрдэнэцогт сум Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд зориулан 11.0 сая төгрөгийн фитнес клубийн тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог сумын Засаг даргын 2019.02.04-ны өдрийн А/05 дугаар захирамжаар байгуулсан байна. Тендер зарлаад ААНэгж ирээгүй тул шууд гэрээ байгуулсан гэх боловч хурлын тэмдэглэл байхгүй, мөн Үнэлгээний хорооны зөвлөмжийг Засаг даргад 2019.02.03-нд хүргүүлсэн огноо үнэлгээний хороо байгуулсан өдрөөс өмнөх өдрөөр бичигдсэн ба энэ нь тендер зарласныг нотлох боломжгүй байна.
- Шинэжинст сум: Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардалд 79.5 сая төгрөгийг баталж 73.3 сая төгрөгийн тендер зарлалгүй шууд гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 24.4¹⁰, дэх заалтыг зөрчсөн тул цаашид алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.



2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр
2019 онд 298 төсөл, хөтөлбөр, арга

⁸ 13.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

⁹ 7.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

¹⁰ 24.4. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.



хэмжээнд 7,223.7 сая төгрөгийг зарцуулсан.

Өмнөх оноос шилжиж ирсэн болон 2019 онд батлагдсан ажлаас гэрээ байгуулсан 7,512.0 сая төгрөгийн 299 төсөл арга хэмжээнээс 280 ажил 6,412.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бөгөөд эдгээрээс 44 төсөл арга хэмжээний 121.1 сая төгрөгийн санхүүжилтыг дутуу олгосон байна. Харин дутуу хэрэгжсэн 1,484.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 19 ажилд 932.1 сая төгрөгийн санхүүжилтыг шилжүүлсэн бөгөөд 809.9 сая төгрөгийн 29 ажил огт хэрэгжээгүй, санхүүжилт олгоогүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөс Баацагаан, Баянговь сумд сумын ИТХ-аар батлаагүй 13.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлж Төсвийн тухай хуулийн 60.3.6¹¹ заалтыг зөрчсөн тул зөрчил давтан гаргахгүй зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

Аудитын илрүүлэлт:

- Баянговь суманд аж ахуйн нэгж байгууллагуудыг цэвэр усны нэгдсэн системд холбох 10.0 сая төгрөг
- Баацагаан сум Баянбулаг, Товгор багуудад үүрэн телефоны үүрэн сүлжээ тавих төсөл арга хэмжээнд 3.4 сая төгрөг

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгахад төслийн хөрөнгийг зориулалт бусаар, батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан, дутуу болон чанаргүй хийгдсэн, санхүүжилтийг бүрэн авсан боловч төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Жинст сумын цагдаагийн хэсэгт 3.0 сая, Баацагаан суманд 2.5 сая төгрөгийн торгуулийн пос машин. Баянхонгор суманд 4 ширхэг торгуулийн пос машин, хэвлэгчийн хамт нийт 9.2 сая, Бөмбөгөр суманд 1.6 сая, Баянхонгор суманд 1.9 сая төгрөгийн согтолтын хувь хэмжигч, тандагч төхөөрөмж, Баянхонгор суманд олон нийтийн цагдаа нарт гар станцыг худалдан авахад 2.9 сая, нийт 20.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулан Төсвийн тухай хуулийн 60.3.1¹² заалтыг зөрчсөн тул зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмжийг сумдын Засаг даргад хүргүүлээ.
- Жинст сумын Байгаль орчны боловсрол олгох төсөл арга хэмжээнээс 6.0 сая төгрөгөөр ном товхимол хийлгэхээр төлөвлөсөн боловч өнөөг хүртэл хийгдээгүй, авлагаар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2¹³ зөрчсөн тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ./ ном хэвлэлтэд орсон гэсэн тайлбар ирүүлсэн/

¹¹ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

¹² орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ

¹³ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;



- Баянговь сум хууль эрх зүйн сургалт зохион байгуулах зардалд 1.8 сая төгрөг зарцуулахаар батлагдсан байхад сургалт зохион байгуулаагүй хөрөнгө бэлтгэж зориулалт бусаар зарцуулж 1.8 сая төгрөгийн өртөгтэй 13 зөөврийн компьютер, 0.4 сая төгрөгийн принтер авсан ба батлагдсан төсөвт өртгөөс 0.4 сая төгрөгийн хэтрүүлэн зарцуулсан, сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг хийхээр 5.0 сая төгрөг батлагдсан 0.2 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан тул Төсвийн тухай хуулийн 41.2.2¹⁴ дахь заалтыг зөрчсөн тул нийт 0.6 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.
- Хүрээмарал сум : Цэцэрлэгийн гадна талбайн тоглоом нийлүүлэхээр “Сод арвай” ХХК нь 6.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, хүүхдийн элсний хайрцаг 0.5 мянган төгрөг дутуу нийлүүлсэн тул төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.
- Малчдыг малжуулахад зориулан Баян-Овоо сум 12.0 сая төгрөгийг 4 малчинд, Баацагаан сум 32.5 сая 13 малчинд, нийт 44.5 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгож Төсвийн тухай хуулийн 60.3.1¹⁵ заалтыг зөрчсөн тул ОНХС-д эргэн төлүүлэх зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлээ.

Мөн аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлаас дутуу гүйцэтгэсэн ажлуудад зөрчил арилгах арга хэмжээг аудитын явцад авсны үр дүнд 27.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг гүйцэтгэх албан шаардлага өгснөөр, дараах ажлуудыг гүйцэтгэж сумын ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Баянцагаан сум Баянбулаг багийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд тохижилт хийхээр 5.0 сая төгрөг батлагдаж иргэн С.Гантөмөртэй 2019.07.01 гэрээ байгуулж барилгын материалыг худалдан авч ЗДТГ-т орлого авсан хийж гүйцэтгээгүй байсан бөгөөд аудитын явцад хийж гүйцэтгэсэн байна.
- Галуут сум Үнэгт багт хадлангийн 2 га газар хаших 7.2 сая төгрөгийн ажил 2019 онд хийгдээгүй 2020 оны 8 сард хийгдсэн боловч техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг хангаагүй байсныг дахин хашаалж 2020 оны 10-р сарын 22-нд ажлыг комисс хүлээн авсан байна.
- Гурванбулаг сум: Мал нядалгааны байрны засварт 3.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан ба тус ажлыг дутуу гүйцэтгэсэн байсанд аудитын явцад зөрчлийг арилгасан болно.
- Бөмбөгөр сумын сургуулийн тохижилт 3.0 сая төгрөгийн сургуулийн гадна талын хайсжуулалтын дутуу ажлыг аудитын явцад гүйцэтгэн дуусгаж зөрчлийг арилгасан.
- Баянбулаг сумын орон нутгийн давсан орлогоос 8.0 сая төгрөгийг ЗДТГ-ын автомашины парк шинэчлэлд зарцуулахаар ИТХ-аар батлуулсан бөгөөд тус мөнгийг ОНХС-гаас зарцуулсныг буцаан санд төлүүлэхээр албан шаардлага хүргүүлснээс аудитын явцад 5.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Баянговь сумын ОНХС-гаас “Цагаан гол”-ын гүүрний төлбөрт 2017 оны 10-р сарын 06-ны өдрийн 131/ШШ2017/00694 тоот Шүүхийн шийдвэрийн дагуу “Баян

¹⁴ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

¹⁵ орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.



тээх” ХХК-д 15.0 сая төгрөгийг, Шинэжинст сум 2014 онд хийгдсэн 04 шугамын өргөтгөлийн ажилд 2019.07.02-ны өдрийн 11903006/01 тоот Шүүхийн шийдвэрийн дагуу 18.6 сая төгрөгийг “Алтан завьяа ундарга ХХК-д тус тус олгосон байна.

2.2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4¹⁶, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам” 6.1, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9,12¹⁷ дахь заалтыг зөрчсөн тул 1,696.3 сая төгрөгийн хөрөнгө орлого аваагүй байгаа тул холбогдох шийдвэрийг гарган орлогод бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- Галуут сум: 16.0 сая төгрөгийн өвс тэжээл бэлтгэсэн боловч ЗДТГ-ын бараа материалд орлого аваагүй;
- Жинст сум: Ахмадын өргөөний халаалт 11.8 сая төгрөгийн засвар хийж 2020 онд ашиглаж эхлэхээр ажил хүлээлцсэний дараа хөрөнгө орлого авахаар хойшлуулсан;
- Баянлиг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга хэмжээнд зарцуулсан 17.9 сая төгрөгийн;
- Баянговь сумын тариалангийн талбайн услалтын систем 10.0 сая, аж ахуйн нэгж байгууллагыг цэвэр усанд холбох 10.0 сая төгрөгийн арга хэмжээг;
- Өлзийт сум ОНХС-гийн хөрөнгөөр 9.9 сая төгрөгийн 04 шугамын өргөтгөлийг эзэмшигч тогтоолгохоор Баянхонгор аймгийн Эрчим Хүч ХХК-д хүсэлт явуулсан боловч Баянхонгор Эрчим Хүч ХХК-д хөрөнгө орлого аваагүй;
- Хүрээмарал сум: Хүүхдийн цэцэрлэгийн гадна талбайд 2.2 сая төгрөгийн хүүхдийн тоглоомыг 2020 оны 6 сард нийлүүлсэн боловч цэцэрлэг хөрөнгөнд орлогоор аваагүй;
- Баян-Өндөр сум: Хүүхдийн цэцэрлэгийн гадна тоглоом 10.0 сая төгрөгийг хөрөнгөнд орлогоор бүртгээгүй;
- Шинэжинст сумын 33.0 сая төгрөгийн өртөгтэй хог тээврийн автомашин 92-56 БНА улсын дугаартай “HYUNDAI GOLD” маркийн автомашин нь иргэн З.Мөнхтөрийн нэр дээр бүртгэлтэй, 50.0 сая төгрөгийн өртөгтэй Gs10-70 маркийн универсал трактор гаалийн бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээ байхгүй байна. Богд сум 25.0 сая төгрөгийн өртөгтэй хог тээврийн 91-71 БНХ улсын дугаартай “MITSUBISHI CANTER” маркийн автомашины улсын бүртгэлийн гэрчилгээ нь иргэн Э.Мөнхжингийн нэр дээр бүртгэлтэй ЗДТГ-ын эзэмшилд шилжээгүй байна.

¹⁶ 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

¹⁷ 8.6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ.



Баянхонгор суманд 6 төсөл арга хэмжээнд 115,4 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй зөрчил илэрсэн тул холбогдох шийдвэрийг гаргуулж хөрөнгө орлого авах албан шаардлагыг Баянхонгор сумын Засаг даргад хүргүүлж байна. Үүнд:

- “Дэлгэрэх их богд” ХХК-ийн барьсан 4,0 сая төгрөгийн үнэ бүхий гамшгаас хамгаалах нөөцийн хашааг орлогоод аваагүй.
- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2017, 2018 онд “Жаргантайн хөх тариа” ХХК-ийн гүйцэтгэсэн Авто тээврийн үйлчилгээний төвийн хуучин байршлын хашааны гадна байрлалтай 34,5 сая төгрөгийн үнэтэй Сити-ОО, Авто тээврийн үйлчилгээний төвийн шинэ байршлын дэргэд байрлалтай 59,8 сая төгрөгийн үнэтэй 54м2 талбайтай 6м*9м хэмжээтэй Сити-ОО буюу нийтийн бие засах газрын хөрөнгийг орлогоод аваагүй байна.
- Нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулсан 8,5 сая төгрөгийн үнэ бүхий 25ш хогийн савыг хөрөнгөд орлогоор бүртгээгүй.
- Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багт хийгдэх “Замын хяналтын пост”-ын 5.0 сая төгрөгийн ажил бүрэн хийгдээгүй, зөвхөн хяналтын байр гэх контейнерыг суурийн хамт бэлтгэж, тоног төхөөрөмжийг холбож суурилуулаагүй зөрчил илэрч, ажлын гүйцэтгэлийг хангаж, хөрөнгийг орлогоод авхуулах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ
- Баянхонгор сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэх 3,6 сая төгрөгийн үнэтэй нийтийн эзэмшлийн орон сууц, төрийн болон төрийн байгууллагын гэрлэн хаягийг /Хоггүй цэвэр хотод амьдарцгаая, Ногоон байгууламжаа хайрлан хамгаалъя, Багийн хөгжлийн төв, Эрдэм ном эрхэм баян, Хөдөлмөрийн хүний төлөө/ хөрөнгөд бүртгэх шийдвэр гараагүй байна.

Мөн Баянхонгор аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс 8 төсөл арга хэмжээнд 1,425.0 сая төгрөгийг хөрөнгө орлого аваагүй тул зөрчил арилгах албан шаардлагыг Баянхонгор аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

- Аймгийн ИТХ-аар хөрөнгө эзэмшигчийг тогтоосон боловч хөрөнгийг ашиглагч байгууллага нь хөрөнгийг орлогоод аваагүй байна. Үүнд: Баянхонгор сумын 2,3 багийн гэр хороололд баригдсан спорт талбай, цэцэрлэгт хүрээлэн 116,7 сая төгрөг, Аймгийн Хөгжимт драмын театрын дотор халаалтын засвар 29,6 сая төгрөг, Баянбулаг сумын ЗДТГ-ын барилгын их засвар 236,7 сая төгрөг.
- Аймгийн ИТХ-аар хөрөнгө эзэмшигчийг тогтоох шийдвэр гараагүйгээс дараах төсөл арга хэмжээг хөрөнгөд бүртгээгүй байна. Үүнд: 5, 6-р багийн Наранмандал өрхийн эмнэлгийн барилгын дотор халаалтын шугам 30,0 сая төгрөг, Бууцагаан сумын Өлзийт багийн төв 69,8 сая төгрөг,
- 2019-2020 он дамжин хийгдсэн төсөл арга хэмжээг ажлын комисс хүлээн авсан боловч аймгийн ИТХ-аар хөрөнгө эзэмшигч тогтоох, хөрөнгө орлого авах шийдвэр гараагүй Баянхонгор сумын төвд 1 км хатуу хучилттай авто зам 380,0 сая төгрөг, Баянхонгор аймгийн спорт хорооны барилгын их засвар 275,4 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн их засвар 150,2 сая төгрөг, Баянхонгор сумын 4 дүгээр багийн спорт заал бүхий багийн хөгжлийн төв болон музейн барилгын дулааны холболт 136,6 сая төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.



Бүлэг 3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээнд аймгийн ЗДТГ хууль, журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй, ОНХС-гаас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ орон нутагт бодит дэмжлэг болж байгаа боловч зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй, арчлалт хамгаалалт байхгүйгээс хөрөнгө эзэнгүйдэж, сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

3.1 Баянхонгор аймгийн ОНХС-гийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт хийгээгүй, мөн Галуут, Богд, Бууцагаан сумд ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавиагүй байна

3.1.1 Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1¹⁸, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4¹⁹-т заасны дагуу сумдын ИТХ-ын дэргэд хяналтын хороо 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна. Гурванбулаг, Шинэжинст, Өлзийт, Жинст сумууд ОНХС-гаар хэрэгжсэн ажилд олон нийтийн оролцоотой хяналтыг хэрэгжүүлсэн, Галуут, Богд, Бууцагаан сумаас бусад сумд ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд сумын хяналт тавих ажлын хэсэг төсөл арга хэмжээг түүвэрлэн хяналт тавьж ажилласан байна.

Баянхонгор сумын ОНХС: Сумын Засаг даргын 2018.05.22-ны өдрийн 129 тоот захирамж, 2019.06.07-ны өдрийн А/159 тоот захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудын гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалт хийж, хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэсэн ажилд 2019 онд 7 удаа хяналт хийж, мөн 2019.12.04-нд сумын ОНХС-ийн хяналтын зөвлөлийн хурал хийж ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, түүнд хийсэн хяналт, шалгалтын талаар мэргэжилтний мэдээллийг сонсож хэлэлцэж, дүгнэснээр “Гамшгаас хамгаалах нөөцийн агуулах барих”, “Шаргалжуут тосгонд замын хяналтын пост байгуулах” ажлаас бусад ажлыг бүрэн гүйцэтгүүлжээ.

¹⁸ 9.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

¹⁹ 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.



3.1.2 Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5²⁰, 9.6²¹-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хэрэгжүүлэх байтал тус хэлтэс нь дээрх үүргээ хэрэгжүүлээгүй байна. Иймд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээр хийлгэхийг аймгийн Засаг даргад зөвлөмж өгөв.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2²²-т заасны дагуу Баянхонгор аймгийн сумууд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд оруулсан байдлыг шалгахад Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгийн мэдээллээс бусад сумууд 2019 оны мэдээллийг бүрэн оруулсан байна. Баянхонгор аймгийн ОНХС-гийн мэдээллийг 2017, 2018, 2019 онд өмнө ашиглаж байсан мэдээллийн программд бүрэн оруулсан. шинэчилсэн программд мэдээллийг оруулахад 1 сарын хугацаа шаардлагатай бөгөөд зөвхөн ХОХБТХ биш Орон нутгийн өмчийн алба худалдан авах ажиллагааг, СТСХ нь төсвийн хуваарийг тус тус оруулахаар байгаа гэсэн тайлбарыг ирүүллээ. Иймд аймгийн СТСХ-ийн даргад журмын 10.3.1²³ заалтыг хэрэгжүүлэн удирдлага мэдээллийн системд бүртгэгдсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зөвлөмжийг хүргүүлэв.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй барилгын их засварууд шинээр баригдаж буй барилгад захиалагчийн хяналтыг Баянхонгор аймгийн ГХБХБГ барилга угсралтын үе шатуудад хяналт тавьж байгаа боловч хангалтгүй байна.

²⁰ 9.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ.

²¹ 9.6.Энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ.

²² 10.2 ОНХС-гийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналт, бүртгэлд удирдлагын мэдээллийн систем ашиглах ба орлогын шилжүүлгийг төлөвлөгөө, батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, санхүүжилтыг хуваарь, төлбөрийн бүртгэнэ.

²³ ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд бүртгэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.



Иймд аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр баригдаж буй барилга, барилгын их засварт захиалагчийн хяналтыг ГХБХБГ-аар хийлгэн үр дүнг тооцож байх зөвлөмжийг ХБХОТХ-ийн дарга, сумдын Засаг дарга нарт зөвлөмжөөр хүргүүлэв.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн хэрэгжүүлэгч 20 суманд ажиллаж жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, үнэлгээ хийх аргачлалын талаар сургалт хийгдсэн бөгөөд сумдад журмын дагуу хяналт хийгдсэн

Баянхонгор аймгийн 2019 оны сум бүрийн ЖГҮ-ний үр дүн, бүлгээр




Сумын нэр	Олон нийтийн оролцоо	Төлөвлөлт	Ил тод байдал	Гүйцэтгэл	ХШҮ	Өмчийн удирдлага	Сумын Үнэлгээ
Орхон	99%	87%	69%	75%	100%	100%	87%
Гурванбулаг	97%	88%	58%	64%	73%	100%	79%
Баянхонгор	98%	95%	53%	71%	65%	52%	78%
Жаргалант	93%	61%	47%	82%	80%	100%	70%
Хүрхмарат	92%	84%	31%	67%	100%	94%	76%
Жинст	97%	83%	52%	23%	100%	79%	75%
Баянбулаг	89%	85%	61%	65%	67%	73%	75%
Эрдэнэцогт	96%	84%	53%	50%	90%	52%	74%
Талуут	94%	89%	44%	54%	85%	77%	73%
Баянцагаан	96%	86%	25%	63%	73%	82%	72%
Шинэжир	86%	77%	56%	21%	100%	79%	72%
Сүмдэн дундаж	85%	81%	49%	56%	87%	78%	72%
Баянбулаг	94%	75%	47%	39%	100%	75%	71%
Баянгоо	91%	87%	58%	35%	100%	74%	70%
Зэг	90%	79%	44%	50%	80%	79%	70%
Баян-Өндөр	90%	90%	44%	30%	67%	88%	70%
Бөгд	72%	69%	47%	61%	100%	85%	69%
Баянцагаан	89%	79%	42%	50%	100%	73%	68%
Буддаман	90%	71%	61%	41%	87%	89%	67%
Баян-Овоо	90%	72%	58%	49%	100%	67%	62%
Баянгол	92%	70%	39%	61%	73%	64%	61%

- Олон нийтийн оролцооны бүлэг үзүүлэлтээр Жаргалант, Эрдэнэцогт сумд 100 хувийн үнэлгээ авсан. **Баян-Өндөр, Баянгол сумдаас бусад нь 60 хувиас дээш үнэлгээ авчээ.**
- Төсвийн төлөвлөлтөний бүлэг бүтд 69%-аас дээш үнэлэгдсэн
- Ил тод байдлын бүлгийн хувьд бүх сумдын хувьд хангалтгүй үнэлэгдсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн үнэлгээний хувьд **Баян-Овоо, Жинст, Баянгоо, Баянбулаг, Бууцагхан сумууд 50-аас доош буюу хангалтгүй үнэлгээтэй байна.**
- ХШҮ-ний бүлэг үзүүлэлтийн хувьд бүх сумдууд 60-аас дээш хувьтай үнэлэгдсэн.
- Өмчийн удирдлагын бүлгийн хувьд **Баянхонгор, Эрдэнэцогт** сумуудаас бусад нь 60-аас дээш хувьтай үнэлэгдсэн.

байна.

Мөн аудитын явцад 661 иргэнээс ОНХС-гийн үйл ажиллагааны талаар санал асуулга авахад 267 иргэн орон нутгийн сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл сайтай, 364 иргэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хяналт тавьж оролцдоггүй, ОНХС-гийн заавар журмыг судалж үзсэн эсэхийг асуухад 366 иргэн судалж үзээгүй гэсэн хариулт өгсөн нь иргэдийн идэвх, оролцоо хангалттай бус байгааг харуулж байна.





3.2 Өмнөх оны аудитын зөвлөмжөөр өгсөн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулдаг, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй зэрэг зөрчлүүд тайлант онд давтагдсаар байна.

3.2.1. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2²⁴-д заасны дагуу 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сумд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т журамд заасан хугацаанд ирүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.9²⁵-д заасны дагуу аймаг, сумдын 2019 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж журамд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлээгүй бөгөөд ХОХБТХ-ийн мэргэжилтнээс тодруулахад жилийн эцсийн тайлан мэдээг албан бичгээр хүргүүлээгүй болно гэсэн тайлбарыг ирүүллээ. Иймд цаашид журмын 9.9 дахь заалтыг хэрэгжүүлэн Баянхонгор аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээг нэгтгэн цаглаварт хугацаанд хүргүүлж ажиллахыг ХБХОТХ-ийн даргад зөвлөмжөөр хүргүүлж байна.

Аймаг, сумын ОНХС-гийн төсвийн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй ба хуулийн 6.1.1²⁶, 6.3.9²⁷-д заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд Баянхонгор аймаг, Хүрээмарал, Баянбулаг, Баян-Овоо, Баян-Өндөр, Шинэжинст, Баянлиг сумаас бусад сумд мэдээлж, хэрэгжилтийг ханган ажиллажээ.

3.2.2 Аймгийн орон нутгийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтын нийцлийн аудитаар аймгийн ИТХ-д 1 зөвлөмж, аймгийн Засаг даргад 1 акт, 5 албан шаардлага, 5 зөвлөмж, Сумдын ИТХ, Засаг дарга нарт 1 акт, 8 албан шаардлага, 7 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн гэсэн хариуг ирүүлсэн байна.

²⁴ 9.2.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.

²⁵ 9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

²⁶ 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

²⁷ 6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.

Өмнөх аудитын акт, албан шаардлага,
зөвлөмжийн биелэлт

Хүснэгт 5 /сая төг/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлбөрийн акт	Зөвлөмж	Албан шаардлага
өгсөн	тоо	2	12	13
	сая.төг	1.3	61	822.2
хэрэгжсэн	тоо	2	10	12
	сая.төг	1.3	61	682.2
хэрэгжилт	хувь	100%	83%	83 %

Хүснэгтээс харахад өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан, 12 зөвлөмжөөс 2 зөвлөмж хангалтгүй хэрэгжсэн, 13 албан шаардлагаас 140,0 сая төгрөгийг 1 албан шаардлага биелээгүй байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 83 хувьтай байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагаас бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй заалтыг дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт 6

д/д	Илрүүлсэн зөрчлийн товч утга	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн биелэлт
Аймгийн ИТХ-ын даргад /зөвлөмж/		
1	Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагнал бүртгэлийн явцад ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооны тавих хяналтыг сайжруулж, тайланг ИТХ-аар хэлэлцэж дүгнэлт өгч холбогдох шийдвэр гарган биелэлтийг тооцож байх.	2019.09.19-ны өдрийн аймгийн ИТХ-ын 16/433 албан тоотоор ОНХС-гийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хийх хяналт шалгалтыг тогтмолжуулах, авсан арга хэмжээ, зохион байгуулсан ажлын талаарх тайланг ирүүлэн талаар сумдад албан бичгийг хүргүүлсэн ба энэ арга хэмжээний хүрээнд 11 сумд хяналт хийсэн ажлын талаар тайланг аймгийн ИТХ-д ирүүлсэн. Харин аймгийн ОНХС-гаас хэрэгжсэн төсөл арга хэмжээнд аймгийн ИТХ хяналт тавиагүй, хэрэгжилтийн талаар хурлаар авч хэлэлцээгүй байна. Биелэлт 50%
Сумдын ИТХ, Засаг даргад /Зөвлөмж/		
2	ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосон төсөл, арга хэмжээг баталдаг явдлыг зогсоож, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.	ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосон арга хэмжээг зарим сум хэрэгжүүлж ажиллаагүй байна. 2019 оны ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтаар 6 сум 9 арга хэмжээнд 73.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Сумын хэмжээгээр 4,123.0 сая төгрөгийн арга хэмжээ баталснаас 1.8 хувь нь зориулалт бусаар баталсан байна. Биелэлт 70 %
3	Иргэдээс авсан саналын дагуу Төсвийн тухай хуулийн 58.4.8 дахь заалтын хүрээнд иргэдийн хувийн өмчлөлд засвар тохижилт хийх ажлыг хэрэгжүүлэхдээ иргэдийн оролцоог хангаж, гарах зардлын 50 хүртэл хувийг иргэдээс төвлөрүүлсний дараа арга хэмжээг хэрэгжүүлж байх.	Баян-Өндөр сумын ИТХ хэрэгжүүлсэн байхад Баянхонгор аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Баянхонгор сумын нийтийн орон сууцны 3 байранд 189,9 сая төгрөгийн их засвар хийхэд тухайн байрны оршин суугч иргэдээс засварын зардлыг 50 хувийг аваагүй байна.



1	"Хонгорын шугуй" ХХК нь Баянхонгор-Өлзийт чиглэлийн замын дагуу мод тарих, Баянхонгор сумын ойн зурвасын хамгаалалтыг сайжруулах, аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын урьдчилгаа санхүүжилтийг аваад гэрээний үүргээ биелүүлээгүй гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй байна.	Аймгийн Засаг даргын 2019.05.22 ны А/278 тоот захирамжаар "Хонгорын шугуй" ХХК –ийн дээрх ажлыг шалгаж хүлээн авах ажлын хэсгийг томилсон. Тус ажлын хэсэг ажлын тайландаа "ойн зурвас байгуулах ажил хангалтгүй хийгдсэн, 4558 суулгац тарьсан боловч 941 ш мод ургаж амьдралын хувь нь 21 байна гэж дүгнэсэн нь Байгаль орчин ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 3-р сарын 29-ны А96 /71 тоот тушаалаар батлагдсан журмын 4.5.5 –д заасны дагуу амьдралын хувь 24,9 хувиас доогуур байгаа тул зардлыг нөхөн төлүүлэх шаардлагатай" гэж үзсэн байна. Ажлын хэсгийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна. Биелэлт 0%
---	---	---

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагнал бүртгэлийн явцад ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороог байгуулах, хэрэгжсэн төсөл арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулж, тайланг ИТХ-аар хэлэлцэж дүгнэлт өгч холбогдох шийдвэр гарган биелэлтийг тооцож байх зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүллээ.

Мөн "Хонгорын шугуй" ХХК-ны төрд учирсан хохирлын барагдуулах, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа аймаг, сумдын ОНХС-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 2020 оны 3 дугаар сард хийсэн санхүүгийн аудитаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 66,6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 55.2 сая төгрөгийн барагдуулж Жинст сумын ОНХС 1,6 сая, Заг сум 0,6 сая, Баянхонгор сум ОНХС 9.2 сая төгрөгийг тус тус барагдаагүй байна.

Харин хөрөнгө орлого авах тухай 369,4 сая төгрөгийн 2 албан шаардлага, бүртгэл тайлагналтай холбоотой 124,7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллажээ.



3.2.3 ОНХС-гийн хөрөнгөөр 2016-2019 онуудад хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээ орон нутагт бодит үр дүнгээ өгч байхад түүвэрлэн үзсэн ажлуудаас 753,5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хангалтгүй хийгдэж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д өөрчлөлт оруулах дараах саналыг хүргүүлж байна.

Хүснэгт 7

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ийн заалт	“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д зөрчилдөж буй	Тайлбар
4.1 “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ.” гэж заасан бөгөөд харин Төсвийн тухай хуулийн 58-д зүйлийн 58.4.10. “орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;”	Журмын 4.2.ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно. 4.2.5.Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал;	Төсвийн тухай хуулиар Орон нутгийн байгууллага дотор аймаг сумын ЗДТГ-ын барилга байгууламжийн засвар, шинээр барилга байгууламж барих боломжтой харагдаж байна. Иймд журмаар яг ямар байгууллагад барилга байгууламж барих, их засвар хийж болохыг байгууллагын нэр төрлөөр тодорхой тусгах
4.2.ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно. 4.2.1.Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан зүйлс; Төсвийн тухай хуулийн “60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.”	Журмын 11.2.ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.	Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг аймаг, сумдын иргэдийн хурлын төлөөлөгчид санал оруулж ИТХ-аар батлуулан санхүүжүүлж байхад ямар хариуцлага тооцдоггүй. Иймд хариуцлагыг хэрхэн тооцохыг тодорхой тусгах
Журмын 5.8.Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна.	6-р сард болговол сурагчдын зуны амралт эхэлсэнтэй холбоотойгоор малчдад хуралд оролцох цаг хугацааны боломж илүү болж иргэдийн оролцоо нэмэгдэх	



Журмын 9.4."ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина."	Журамд хяналт тавих талаар тусгасан боловч ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудад хяналт тавих зардлыг зарцуулах журам байхгүй, олон нийтийн оролцоотой хяналт тавих заалт байгаа боловч олон нийтийн урамшуулах заалт байхгүй байна. Энэ нь нэг талаас тус сангаас хийгдэж буй төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн шатанд тавих хяналт хийгдэж чадахгүй байгааг харуулж байна. Зөвхөн барилга байгууламжид захиалагчийн хяналтын зардлыг тусган суутган тооцож байна. Иймд сумын ОНХС-гийн тодорхой хувийг гүйцэтгэлийн болон ашиглалтын хяналтад зарцуулах журмыг батлах.
Журмын 3.1.7 "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах;	Журамд заасан заалт хэрэгжихгүй байгаагаас ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээнд комисс хүлээн авснаас хойш хамгаалалт, ашиглалт, арчлалт хамгаалалт байхгүй байна. Аймаг, сумдын ИТХТ-ээс өмчийн эзэмшигч тогтоох шийдвэр гарч байгаагаас түүний ашиглалтын зардал нь төсвийн төсөлд тусгагдахгүй байна.
Журмын 10.т "ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем" -ын талаар	ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт хийдэг төр захиргааны болон хөндлөнгийн байгууллагууд "Удирдлагын мэдээллийн систем"-д шууд нэвтрэх, оруулсан мэдээллийг аймгийн хэмжээнд нэгдсэн байдлаар нэгтгэж гаргах боломжгүй байна. Иймд удирдлагын мэдээллийн системийг илүү боловсронгуй болгож хөгжүүлэх, мэдээллийн санд оруулсан мэдээллийг төрөл бүрийн байдлаар нэгтгэж харах боломжтой болгох сайжруулалт хийх шаардлагатай.
Журмын 11-т "Хариуцлага"	• ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ нь явцын хяналтаар үр дүнгүй тодорхой болсон тохиолдолд гэрээг цуцалж, хэрэгжилтийг таслан зогсоож төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх. • Сангийн хөрөнгийг зориулалт бус арга хэмжээнд баталсан болон ИТХ-аар батлаагүй зэрэг ажлуудын санхүүжилтийн эрхийг нээхгүй байхыг аймаг, сумын Төрийн санд үүрэг болгож оруулах саналыг журамд тусгах.

ҮАГ-аас өгсөн чиглэл

ОНХС-гийн хөрөнгөөр 2016-2019 онуудад хийж гүйцэтгэсэн ажлуудаас дараах төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжилд бодитой үр нөлөө үзүүлсэн гэж тодорхойлж байна. Үүнд:

1.Баянхонгор сумын нутаг дэвсгэрт 8 багт спорт заал бүхий нийт 3,272.2 сая төгрөгийн өртөг бүхий барилга баригдаж хүүхэд, залуучууд спортын 11 төрлийн секц дугуйланд тогтмол хичээллэснээр чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, цаашид спортын амжилт гаргах, компьютер тоглоомд донтох, гэмт хэрэг зөрчилд уруу татагдахаас урьдчилан сэргийлэх зэрэг нийгмийн сөрөг байдлыг



бууруулахад ач тусаа өгсөн. Үүний үр дүнд сүүлийн жилүүдэд спортын олон төрөл дээр тамирчид амжилт үзүүлж улсын болон олон улсын, тив дэлхийн аваргаас медаль хүртэж Баянхонгор аймгийн болон Монгол улсын нэрийг гаргаж байгаа нь тус хөрөнгө оруулалтын үр дүнг харуулж байна.

2. Баянхонгор сумын 3,6-р баг 4,5-р багуудын айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх ухаалаг тарифт тоолуурыг 2018 оноос нийт 290.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн. Энэхүү ажлын үр дүнд 1270 айл өрхүүд шөнийн цагаар цахилгааны төлбөрөө 50 хувиар, 2020 онд 100 хувь хөнгөлүүлэх нөхцөл бүрдсэн.

3. Аймаг, сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, сумдын гудамжны болон сургууль цэцэрлэгийн камержуулалтад 2019 онд 525.7 сая төгрөгийг ОНХС-аас аймаг, сумын ИТХ-аар батлуулан гүйцэтгэсэн байна. Энэ ажлын үр дүнд гэмт хэргийн гаралт буурч, иргэд аюулгүй орчинд амьдрах, сургуулийн сурагчдын аюулгүй байдал хангагдаж байна.

4. 2013-2019 онуудад дараах сумууд урт хугацааны хөтөлбөр боловсруулан судалгаа шинжилгээ хийсний үр дүнд Бөмбөгөр суманд малын үүлдэр угсааг сайжруулах нарийн ноолуур, мах, сүүний чиглэлийн Улаан ямааны омгийг нийт 32,3 сая төгрөг, Шинэжинст суманд ноолуурын чиглэлийн “Залаа жинст” идэрэнгийн цагаан ямааны омгийг 35,0 сая зарцуулж ХХААХҮ-ийн сайдын тушаалаар баталсан. Харин Баянбулаг суманд махны чиглэлийн хонь “Баянбулаг омог”-ын судалгаа шинжилгээний ажилд 61,8 сая төгрөгийг зарцуулж омгийг батлуулахад бэлэн болсон байна. Аймгийн цагаан ямааны ноолуураар улсдаа танигдах, Баянхонгор аймгийн мах чанараараа бусад аймгуудаас дээгүүрт ороход үр нөлөө үзүүлсэн байна.

5. Хүрээмарал сумын Цоржийн 4-р багийн Мандал хайрхны өвөрт энергийг судлах эрдэм шинжилгээний ажлыг мөн ОНХС-аас 9,8 сая төгрөгөөр санхүүжүүлсэн бөгөөд тус газар нь үзүүлж буй энэргээрэй Дорноговь аймгийн Хамрын хийдийн энергийн төвөөс өндөр үзүүлэлттэй гарсан ба энэхүү судалгааны ажлын үр дүнд Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжих эх үүсвэр болж байна.

Баянхонгор аймаг, сумын 2016-2019 онуудад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим нэг ажлууд гүйцэтгэтэл хангалтгүй, мөн төсөл арга хэмжээг



ажлын хэсгийн комисс хүлээн авч ашиглалтад оруулснаас хойших ашиглалт хангалтгүй, харуул хамгаалалт, арчлалт байхгүйгээс сангийн хөрөнгийн үр өгөөж харагдахгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр 33,3 сая төгрөгийн сумын ногоон байгуулж нэмэгдүүлэх ажлыг “Ази цэцэрлэгжилт” ХХК гүйцэтгэж Баянхонгор сумын Засаг даргын 2019.10.08-ны А/253 тушаалаар томилогдсон ажлын хэсэгт 2019.10.10-ны өдөр хүлээлгэн өгсөн байна. Аудитын явцад ногоон байгууламжид тарьсан модны ургалтыг аймгийн Сум дундын ой анги, Баянхонгор сумын Хотын захирагчийн албаны хот төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн нартай хамтран үзэхэд 2658 ширхэг тарьсан модны ургалт 20 хувьд хүрээгүй байгаа нь ногоон байгууламжид хөрөнгө эзэмшигч тогтоогүй, арчилгаа, усалгааг хариуцсан газар байхгүйгээс тарьж хүлээлгэж өгсөн суулгацад тавих хяналт байхгүй, ажил хариуцсан холбогдох эрх бүхий албан тушаалтнууд ажлын хариуцлага сулаас төсвийн хөрөнгийн үр өгөөж гараагүй байна. Иймд тус зөрчлийг арилгах албан шаардлагыг Баянхонгор сумын Засаг дарга, байгаль орчны байцаагчид хүргүүлж байна.
- Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2017, 2018 онд “Жаргантайн хөх тариа” ХХК-ийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний газрыг түшиглэн 2 нийтийн бие засах газрыг нийт 94.3 сая төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтад оруулсан байхад хэрхэн ашиглах, хамгаалах талаар холбогдох эрх зүйн акт гараагүй байна. Аудитаар ашиглалтын талаар иргэдээс тодруулахад ашиглалт, хэрэглээ муу, БХР-УБ, УБ-БХР чиглэлийн нийтийн тээврийн автобус явах, ирэх цагуудад хагас дутуу ажиллаж ихэвчлэн хаалттай байдаг гэсэн тайлбарыг иргэд болон Авто тээврийн үйлчилгээний төвийн ажиллагсад өгч байгаагаас харахад тус хөрөнгийн ашиглалтын үр өгөөж хангалтгүй байгааг харуулж байна. Иймд тус хөрөнгийг түрээсийн гэрээгээр ашиглуулах зөвлөмжийг Орон нутгийн өмчийн газрын даргад хүргүүлэв.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Елбата ХХК-ийн барьж ашиглалтад оруулсан 2018 оны 154,7 сая төгрөгөөр “Наранмандал” өрхийн эмнэлгийн барилгын сантехникийн ажил хангалтгүй хийгдсэн, вакум цонхоор дулаан алддаг, зарим өрөөний агааржуулалт муу ажиллаж байгаа нь эмнэлгийн орчинд тохиромжгүй байгаа тул Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3²⁸ 14.6²⁹ гэсэн заалтын дагуу гүйцэтгэгч компаниар дээрх засвар үйлчилгээг дахин хийлгэх албан шаардлагыг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга нарт хүргүүлэв.
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 5 ш 48,8 сая төгрөгийн үнэтэй ухаалаг худгийн тоног төхөөрөмжийг Улаанбаатар хотын “ЭХОМН” ХХК нь 2017.12.06-нд суурилуулж хүлээлгэн өгсөн бөгөөд Чандмань- Баянхонгор ХК-д байрлах “Ухаалаг худгийн удирдлагын мэдээлэлтийн систем”-д цахим орчинд техникийн алдаа их, эвдрэл ихтэй учраас тоног төхөөрөмжийг шинэчилснээр одоо төсвийн хөрөнгийг ашиглалтгүй болжээ. Харин 2019 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслөөр 7 ш ухаалаг худгийн 61,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр Баянхонгор аймагт нийлүүлсэн байхад хөрөнгөнд орлого аваагүй, эдгээр тоног төхөөрөмжөөс 5-г нь өмнөх ашиглаж байсан худгийн тоног төхөөрөмжийг сольж суурилуулсан байна. Иймд төслөөс үнэ төлбөргүй ирсэн 61,2 сая төгрөгийн ухаалаг

²⁸ “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”

²⁹ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна



худгийн тоног төхөөрөмжийг хөрөнгөд орлого авах албан шаардлагыг Чандмань-Баянхонгор ХК-д хүргүүлэв.

- Аймгийн ОНХС-ийн 2019 оны хөрөнгөөр нийтийн орон сууцны 30-р байрны 69,8 сая төгрөгийн их засварын ажлыг "Гал гэрэл констракшн" ХХК, 34-р байрны их засварын 113,4 сая төгрөгийн ажлыг "Шайнинг хаус" ХХК гэрээ хийж, гүйцэтгэж, ашиглалтад өгсөн. Аудитаар оршин суугч ирээдээс засварын ажилтай холбогдуулан авсан санал асуулгаар дээрх байрнуудын дээврээс борооны ус гоождог, өвөлд цан зохиж, хүйтэн, дээврийн засвар хангалтгүй хийгдсэн гэсэн санал ирүүлсэн байна. Иймд Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6-д заасны дагуу чанаргүй хийгдсэн дээврийн ажлыг гүйцэтгэгч компаниар дахин гүйцэтгүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга, ажил хүлээн авсан комисс-д хүргүүлэхээр болов.
- Баянхонгор аймгийн ОНХС-гаас 419,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бөмбөгөр сумын спорт заал бүхий оффисын барилгын ажлыг "Халзан хайрхан" ХХК 2017 оны 12-р сард гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажлын санхүүжилтэд нийт 335,0 сая төгрөг олгосон бөгөөд барилгын ажлын явц зогссон, ажил дуусгаж хүлээлгэж өгөх хугацаа дууссантай холбоотойгоор Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд "Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож дүгнэлт гаргуулах, тус ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах" зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжээгүй тул аймгийн Засаг дарга, ХБХОТХ-ийн даргад барилгын ажлыг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлж хүлээн авах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах албан шаардлагыг хүргүүлж байна.
- Баянхонгор аймгийн ОНХС-гийн 2018 оны хөрөнгөөр Галуут сумын Хайрхан 1-р багт 87,5 сая төгрөгөөр "Нүнжигт инженеринг" ХХК нь багийн төвийн барилга, өвсний агуулахын барилгыг барьж 2018 оны 7-р сард хүлээлгэн өгсөн боловч 2020 оны 9-р сарын 25-ны өдрийн байдлаар өвсний агуулахын төмөр дээвэр хуурч, салбарсан, урд хаалга байхгүй, хажуу талын торон хана нурсан байдалтай байна. Энэ нь барилгын тендерийн төсөвт өртөгт өвсний агуулах ханыг доод талыг блокоор өрөх, шалыг цементлэх, зэрэг ажлууд зураг төсвийн дагуу хийгдээгүй чанаргүй хийгдсэн байхад Барилга байгууламж хүлээн авах комисс хүлээн авч, хариуцлагагүй хандсан тул арга хэмжээ тооцох. Гүйцэтгэгч компаниар энэ талаар утсаар холбогдоход тухайн багийн төв, өвсний агуулахын барилгыг тухайн сумын өөрсдийнх нь зураг төсвөөр хийсэн, ашиглалтад оруулж өгснөөс хойш 2 удаа очиж засвар үйлчилгээ хийгдсэн, мөн тухайн багийн төв болон өвсний агуулахыг харуул хамгаалалт, ашиглалт байхгүйтэй холбоотой гэсэн тайлбарыг өгсөн болно. Иймд гүйцэтгэгч компаниар өвс тэжээлийн агуулахын барилгын засварыг буруутай этгээдээр дахин гүйцэтгүүлэх, албан шаардлагыг аймгийн Засаг дарга болон ХОХБТХ-ийн даргад хүргүүлэв.

Аудитаар нийт 2,173.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,830.4 сая төгрөгийн зөрчил арилгах хугацаатай албан шаардлага, 342.4 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

**Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал**

ОНХС-гийн тайлантай холбоотой саналыг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2020.11.04-ны өдрийн 2/1492 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ИРҮҮЛСЭН САНАЛ	
1	Баянхонгор аймгийн ОНХС-гийн мэдээллийг 2017, 2018, 2019 онд өмнө ашиглаж байсан мэдээллийн программд бүрэн оруулсан байсан. 2020 онд программ шинэчлэгдсэнтэй холбоотогоор дахин 2018 оноос хойшхи хөрөнгө оруулалтын ажлуудыг хийх чиглэлгийг өгсөн.
2	Он дамжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлууд 2020 онд дууссан тул өмчид бүртгүүлэх ажил 2019 онд хийгдэх боломжгүй Үүнд Биеийн тамир спортын газрын их засвар 275.4 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн их засвар 150.2 сая төгрөг, Баянхонгор сумын төвд 1 км хатуу хучилттай автозам 380.0 сая төгрөг. Баянхонгор сумын 4 дүгээр багийн спорт заал бүхий багийн төв болон аймгийн Музейн барилгын холболтын ажил 136.6 сая төгрөг
3	2019 оны сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн эцсийн нэгтгэл тайланг 2020 оны 02 дугаар сарын 10-ны дотор Сангийн яаманд емайл хаягаар хүргүүлсэн бөгөөд албан бичгээр явуулаагүй болно. Эцсийн байдлаар илгээсэн нэгтгэл тайланг мөн өдөр Алтантуягийн аблээр хүргүүллээ
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	
1	Тайлбарыг аудитын тайланд тусгасан.
2	Аудитын тайланд 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгуудийг нягтлан бодох бүртгэлд хөрөнгө авсан байдал, мөн аймаг, сумын ИТХ-ын хөрөнгөд эзэмшигч тогтоох, хөрөнгө орлого авах шийдвэрүүдийг үндэслэн тусгасан болно.
3	Тайлбарыг аудитын тайланд тусгасан.

**АУДИТЫН ДҮГНЭЛТ**

Нийцлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. ОНХНС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг төлөвлөснөөс 193,5 сая төгрөг дутуу олгосон, аймаг сумдын ОНХС-д орох хандив, тусламжийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 291.2 сая төгрөгөөр тасарч сангийн төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.
2. Сумдад олгох орлогын шилжүүлгийг төсвийн хуваарийн дагуу олгоогүй нийт санхүүжилтийн 57 хувийг 9-12 сард олгосон нь аймагт ОНХНС-гаас олгож буй орлогын шилжүүлэгээс хамаарсан байна.
3. Жаргалант, Заг, Бөмбөгөр, Өлзийт сумууд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн санал аваагүй 144.9 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг сумын ИТХ-р баталсан байна.
4. Эрдэнэцогт, Шинэжинст сумууд Төсөл арга хэмжээг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1 -д заалтыг зөрчин шууд гэрээ байгуулсан байна.
5. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 60.3.1 –т заасан заалтыг зөрчин 73,6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 1628,2 сая төгрөгийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 заалтыг зөрчин данс бүртгэлд аваагүй байна.
6. Баянхонгор аймгийн ОНХС-аас хийгдэж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хийгдэж буй хяналт хангалтгүй, аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.
7. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.9³⁰-д заасны дагуу аймаг, сумдын 2019 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж журамд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлээгүй байна.
8. Өмнөх оны аудитын зөвлөмжөөр өгсөн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулдаг, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй зэрэг зөрчлүүд тайлант онд давтагдсаар байна.
9. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээ орон нутагт тодорхой хэмжээний үр дүн өгсөн боловч зарим арга хэмжээ нь ажлын комисс хүлээн авснаас хойш арчлалт, ашиглалт, хамгаалалт хангалтгүй байгаагаас сангийн хөрөнгийн үр өгөөж бүрэн харагдахгүй байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

6417143544

³⁰ 9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

**АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

2020.11.04

Баянхонгор хот

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат танаа

1. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагнал бүртгэлийн явцад ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороог байгуулах, хэрэгжсэн төсөл арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулж, тайланг ИТХ-аар хэлэлцэж дүгнэлт өгч холбогдох шийдвэр гарган биелэлтийг тооцож байх.

Хоёр. Аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан танаа

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг 9.5-д заасны дагуу аймгийн ЗДТГ-ын ХШҮДА-ын хэлтсээр хийлгэн тайланг журмын 9.6-д заасны дагуу олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажиллах.

2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тайлан, ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг журмын 9.3, 9.7 д заасны дагуу жил бүр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж байх.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн орлого сүүлийн 3 жил биелээгүйгээс төлөвлөгдсөн ажлууд хэрэгжих боломжгүй болж байгаа тул хандив тусламжийн орлогыг бодитоор төлөвлөж байх.

Гурав. Аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа танаа

1. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ ИТХ-аар батлагдаагүй, төсөл арга хэмжээний эрхийг нээж санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох



2. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд бүртгэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлж журмын 10.3.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дөрөв. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч
Г.Цэдэндамба танаа

1. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9 дахь заалтыг хэрэгжүүлэн Баянхонгор аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээг нэгтгэн цаглаварт хугацаанд хүргүүлж байх.

2. ОНХС-гийн удирдлагын мэдээллийн системд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах.

3. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж барилга байгууламж, их засварын ажлыг захиалагчийн хяналтыг аль хэлтэс, агентлаг /ХОХБТХ, ГХБХБГ/ хэрэгжүүлэх вэ гэдгийг шийдвэрлэх.

4. ОНХС-ний хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хөндлөнгийн хяналтад мэргэжлийн байгууллагыг татан оролцуулах, хүлээн авсан ажлын арчлалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналтыг сайжруулж сангийн хөрөнгийн үр өгөөжийн нэмэгдүүлэх.

Тав. Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх танаа

1. ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох, хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд тусгахад хяналт тавьж, ажлын комисс хүлээн авснаас хойш ашиглалт, арчлалт, хамгаалалтыг тодорхой болгон, мөн Баянхонгор сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сити ОО-г хэрхэн ямар хэлбэрээр ашиглуулах талаар шийдвэрлэж, хөрөнгийг ашиглалтыг сайжруулах

Зургаа. Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт

1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 60.3.6³¹ дахь заалт, “Орон нутгийн хөгжлийн үйл ажиллагааны журам”-ын 6.3³² д заасны дагуу багийн иргэдийн нийтийн хурлаас

³¹ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ зарцуулахыг хориглоно.

³² Ажлын хэсэг нь энэ журмын 5.13-т заасан баг, хорооны ИНХ-аас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг эрэмбэлэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг хэлэлцэж, дараагийн төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг жил бүрийн 6 дугаар сард багтаан боловсруулна.



ирүүлсэн санал, эрэмбэлсэн жагсаалт болон аймаг, сумдын үндсэн чиглэлд тусгагдсан хөтөлбөр, төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулж байх.

2. Сумын ИТХ-аар батлаагүй төсөл арга хэмжээ болон Төсвийн тухай хуулийн 60.3.1 заалтад нийцэхгүй төсөл арга хэмжээг ИТХ-р баталж, зарцуулахгүй байх.

3. Төсөл арга хэмжээг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1³³-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

4. Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж барилга байгууламж, их засварын ажлыг ГХБХБГ-тай гэрээ хийж захиалагчийн хяналтыг хийлгэж, зарим төсөл арга хэмжээнд мэргэжлийн байгууллагыг татан оролцуулах, хүлээн авсан ажлын арчлалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналтыг сайжруулж сангийн хөрөнгийн үр өгөөжийн нэмэгдүүлэх.

Нийцлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2021 оны 03 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



³³ 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

**Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал**

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг
Баянхонгор сум, Номгон баг
Вэбсайт: www.bayankhongor.gov.mn
Утас/Факс: (976) 7044 2273

2020.11.04 № 2/1492

таний _____ -ны № _____ -т

Г Санал хүргүүлэх тухай Г

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ


Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны нийцлийн аудитын тайлангаар танилцаад дараахь тусгагдсан ажлуудыг хасуулах саналтай байна.

1.Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн систем нь 2020 онд шинэчлэгдсэн бөгөөд өмнөх хуучин программд 2017, 2018, 2019 оны мэдээллийг нэг бүрчлэн оруулж байсан. 2020 онд программ шинэчлэгдсэнтэй холбоотойгоор дахин 2018 оноос хойшхи хөрөнгө оруулалтын ажлуудыг хийх чиглэлийг өгсөн.

2.Он дамжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлууд 2020 онд дууссан тул өмчид бүртгүүлэх ажил 2019 онд хийгдэх боломжгүй юм. Үүнд: Биеийн тамир спортын газрын их засвар 275,4 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн их засвар 150,2 сая төгрөг, Баянхонгор сумын төвд 1 км хатуу хучилттай автозам 380,0 сая төгрөг, Баянхонгор сумын 4 дүгээр багийн спорт заал бүхий багийн төв болон аймгийн Музейн барилгын холболтын ажил 136,6 сая төгрөг.

3.2019 оны сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн эцсийн нэгтгэл тайланг 2020 оны 02 дугаар сарын 10-ны дотор Сангийн яаманд e-mail хаягаар хүргүүлсэн бөгөөд албан бичгээр явуулаагүй болно. Эцсийн байдлаар илгээсэн нэгтгэл тайланг мөн Алтантуяагийн аблээр хүргүүллээ.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



М.ӨНӨРЖАРГАЛ

1201282

D:\2020\Тамгын газар\Тамгын газрын тоот А4-2020 он.docx